

Ангилалтын код 43.020

Зорчигч тээвэрлэлт. Ангилал ба Ерөнхий шаардлага	MNS 5012:20...
Passenger transportation. Classification and general requirements	MNS 5012:2021 MNS 5122:2013 MNS 6440:2014 MNS 5831:2007 MNS 5231:2003 -ын оронд

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 202... оны ... дугаар сарын ...-ны өдрийн ... дугаар тушаалаар батлав.

Энэхүү стандарт 202... оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн хүчинтэй.

1. Зорилго

Энэхүү стандартын зорилго Монгол улсын нутаг дэвсгэрт автотээврийн хэрэгслээр зорчигч тээвэрлэлтийн ангиллыг тогтоож, зорчигч тээврийн үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллага, иргэн, жолооч, тээврийн хэрэгсэлд болон үйлчилгээнд тавих ерөнхий шаардлагыг тогтооход оршино.

2. Хамрах хүрээ

2.1. Энэхүү стандарт нь зорчигчийн тогтмол болон тогтмол бус тээврийн үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллага, иргэд болон үйлчилгээнд тавих шаардлагыг тодорхойлоход хамаарна.

2.2. Уг стандартыг зорчигч тээврийн үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллага, иргэн, үйлчилгээнд хяналт тавих эрх, үүрэг бүхий байгууллага, албан тушаалтан дагаж мөрдөнө.

2.3. Зорчигчийн дүүжин тээврийн үйлчилгээнд тавих шаардлагыг энэхүү стандартаар тогтоохгүй.

3. Норматив эшлэл

Энэхүү стандартад эш татсан стандарт, баримт бичгүүдэд нэмэлт, өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлд баталсан хэвлэлийг хэрэглэнэ. Үүнд:

- 3.1. MNS 4598, Автотээврийн хэрэгслийн ангилал. Техникийн байдалд тавих техникийн ерөнхий шаардлага;
- 3.2. MNS 4599, Авто тээврийн хөдлөх бүрэлдэхүүний эргономикийн үзүүлэлт;
- 3.3. MNS 5025, Авто үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага;
- 3.4. MNS 5537, Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ. Автозамын дагуух үйлчилгээний байгууламж. Үндсэн шаардлага;
- 3.5. MNS 5347, Автомашины угаалгын үйлчилгээ. Ангилал ба ерөнхий шаардлага.
- 3.6. MNS 5552:2005, Монгол хэлний компьютерын орчны тогтолцоо. Кирилл ба монгол үсгийн нэгдсэн код
- 3.7. MNS ISO 3780, Автотээврийн хэрэгслийн дэлхийн үйлдвэрлэгчийг таних тэмдэг(WMI)-ийн код;
- 3.8. MNS ISO 3779, Автотээврийн хэрэгслийн таних тэмдгийн дугаар (VIN) - Агуулга ба бүтэц.

Нэр томьёо, тодорхойлолт

4.1. Энэ стандартад хэрэглэсэн нэр томьёог дараах утгаар ойлгож, хэрэглэнэ. Үүнд:

4.1.1. Нийтийн тээврийн хэрэгсэл

Зорчигч тээвэрлэхэд зориулсан бүх төрлийн автобус, цахилгаан тээврийн хэрэгсэл, такси;

4.1.2. Зорчигч тээвэрлэлтийн төлөвлөлт

Зорчигч тээвэрлэлтийн төлөвлөлт гэж зорчигчийг нэг цэгээс нөгөө цэгт хүргэхтэй холбогдсон цаашдын бодлого, зорилго, хөрөнгө оруулалт, орон зайн төлөвлөлт болон чиглэлийн сүлжээ, цагийн хуваарь, тээврийн төрлүүдийн хоорондын уялдааг тодорхойлох үйл явц;

4.1.3. Зорчигчийн тогтмол тээвэр

Эрх бүхий байгууллагаас тогтоосон замнал, цагийн хуваарийн дагуу хийгдэх зорчигч тээвэрлэлт;

4.1.4. Зорчигчийн тогтмол бус тээвэр

Зорчигчийн тогтмол тээврээс бусад зохион байгуулалттай хийгдэж буй зорчигч тээвэрлэлт;

4.1.5. Олон улсын зорчигч тээвэрлэлт

Монгол Улсын хилийг нэвтрэн хийх зорчигч тээвэрлэлт;

4.1.6. Хот хоорондын зорчигч тээвэрлэлт

Хот, аймгуудын нутаг дэвсгэрийг дамжин хийх зорчигч тээвэрлэлт;

4.1.7. Орон нутгийн зорчигч тээвэрлэлт

Тухайн аймаг, сумдын нутаг дэвсгэрт хийх зорчигч тээвэрлэлт;

4.1.8. Хотын доторх ба хот орчмын зорчигч тээвэрлэлт

Тухайн хотын болон түүний дагуул хот, дүүргийн нутаг дэвсгэрт хийх зорчигч тээвэрлэлт;

4.1.9. Жуулчин тээврийн үйлчилгээ

Аялал жуулчлалын зорилгоор автотээврийн хэрэгслээр тогтоосон маршрут, хөтөлбөрийн дагуу хийгдэж буй зорчигч тээвэрлэлт; Улс хооронд хийгдэж буй жуулчин тээврийн үйлчилгээ нь улс хоорондын зорчигчийн тогтмол бус тээвэрлэлтэд хамааруулна.

4.1.10. Тусгай сонирхлын аялал жуулчлал

Аялал жуулчлалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.13-т заасан тусгай мэргэжлийн ур чадвар, техник хэрэгсэл шаардсан аялал жуулчлалын үйл ажиллагаа;

4.1.11. Хүүхэд тээвэрлэлт

Тээвэрлэлтийн гэрээний үндсэн дээр хүүхэд тээвэрлэхэд зориулан тоногдсон автобусаар үйлчилгээний тогтоосон замнал, цагийн хуваарийн дагуу гүйцэтгэж буй зорчигч тээвэрлэлт;

4.1.12. Зорчигчийн захиалгат тээвэр

Тодорхой орон зай, цаг хугацаанд, захиалгын дагуу зохион байгуулалттайгаар гүйцэтгэх зорчигчийн тогтмол бус тээвэрлэлт;

4.1.13. Тээвэрлэгч

Тээвэрлэлтийн ажил, үйлчилгээ эрхэлж байгаа этгээд;

4.1.14. Замнал

Зорчигч тээвэрлэх чиглэлийн эхний ба эцсийн зогсоолуудын хооронд батлагдсан зам;

4.1.15. Хөдөлгөөний цагийн хуваарь

Нийтийн тээврийн үйлчилгээнд ажиллах тээврийн хэрэгслийн хөдөлгөөний дэглэмийг тогтоосон баримт бичиг;

4.1.16. Замналын зураглал

Нийтийн тээврийн хэрэгслийн батлагдсан замналын дагуу явах хөдөлгөөний зураг;

4.1.17. Нийтийн тээврийн жолооч

Нийтийн тээврийн хэрэгслийг жолоодох зохих ангиллын эрхийн болон мэргэшсэн жолоочийн үнэмлэхтэй, нийтийн тээврийн хэрэгслийн жолоочоор ажиллаж байгаа хүн;

4.1.18. Нийтийн тээврийн кондуктор

Нийтийн тээврийн кондукторын мэргэшүүлэх сургалтад хамрагдсан, нийтийн тээврийн үйлчилгээнд ажиллаж байгаа хүн;

4.1.19. Нийтийн тээврийн шалгагч

Нийтийн тээврийн үйлчилгээний орлого бүрдүүлэлтэд хяналт тавих, цахим төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагаа, зорчигчдыг аюулгүй, тав тухтай орчинд зорчих нөхцөл бүрдсэн эсэхэд хөндлөнгийн үнэлгээ хийх, зөрчлийг илрүүлэх, баримтжуулах, холбогдох албан тушаалтан, байгууллагад мэдэгдэж зөрчлийг арилгуулах, зөрчлийн тоон мэдээ тайлан гаргах хүн;

4.1.20.

Тээвэр зохицуулагч

Нийтийн тээврийн үйлчилгээний өдөр тутмын үйл ажиллагааны хэвийн байдлыг хангах, хяналт тавих, шаардлагатай тохиолдолд түргэн шуурхай арга хэмжээ авч асуудлыг зохицуулах үүрэг бүхий хүн;

4.1.21. Нийтийн тээврийн мэдээллийн сан

Нийтийн тээврийн салбарын зорчигч тээвэрлэлттэй холбоотойгоор цаг хугацааны үечлэлтэйгээр цугларч буй нэгдсэн цахим болон цаасан хэлбэр бүхий мэдээллийн өгөгдөл;

4.1.22. Ажилчдыг тээвэрлэх үйлчилгээ

Эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн үйлчилгээний замын чиглэлийн дагуу, эсхүл ээлж солилцох хуваарийн дагуу байгууллагынхаа ажилчдыг зөөх зорчигчийн тогтмол бус тээвэрлэлт;

4.1.23. Удирдлага мэдээлэл болон цахим төлбөрийн систем

Нийтийн тээврийн үйлчилгээнд ашиглаж байгаа тээврийн хэрэгслийн бүртгэл хяналт хийх, иргэдэд мэдээлэл өгөх, төлбөрийн нэгдсэн систем бүхий цогц үйл ажиллагаа;

4.1.24. Нийтийн тээврийн удирдлагын төв

Нийтийн тээврийн үйлчилгээний мэдээллийг хүлээн авах, шуурхай удирдлага, зохицуулалтаар хангах, үйл ажиллагаанд нь хяналт тавих, мэдээ мэдээллийг нэгтгэн боловсруулах, нийтийн тээврийн байгууллагуудыг шуурхай удирдан зохион байгуулах үндсэн чиг үүрэг бүхий нийтийн тээврийг нэгдсэн удирдлагаар хангаж буй эрх бүхий байгууллагын мэдээллийн системүүдийн үйл ажиллагааг нэгтгэж буй нэгж;

4.1.25. Хөдөлгөөний хяналтын төхөөрөмж

Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн болон байршлын мэдээллийг автоматаар, эсхүл хагас автоматаар бүртгэж, нийтийн тээврийн удирдлагын төв болон холбогдох нэгдсэн системд мэдээлэх үүрэг бүхий тээврийн хэрэгсэлд суурилуулсан зориулалттай төхөөрөмж;

4.1.26. Олон улсын зорчигч тээврийн зөвшөөрлийн бичиг

– Олон улсын автотээврийн харилцааны тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу эрх бүхий байгууллагаас тээврийн хэрэгсэлд олгосон нэг удаагийн болон олон удаа хил нэвтрэн зорчигч тээвэрлэлт хийх тээврийн хэрэгсэлд олгох зөвшөөрлийн бичиг;

5. Зорчигч тээврийн үйлчилгээний төрөл, ангилал

5.1. Зорчигч тээврийн үйлчилгээг үйлчилгээний давтамж, цагийн хуваарь, чиглэлээс хамааруулан дараах төрөлд хуваана. Үүнд:

5.1.1. Зорчигчийн тогтмол тээвэрлэлт;

5.1.2. Зорчигчийн тогтмол бус тээвэрлэлт (Жуулчин, хүүхэд, ажилчид болон бусад арилжааны зорилготой захиалгат тээврийн үйлчилгээ хамаарна).

5.2. Зорчигч тээврийн үйлчилгээг хамрах нутаг дэвсгэрийн хүрээнээс хамааруулан дараах байдлаар ангилна. Үүнд:

5.2.1. Олон улсын зорчигч тээвэрлэлт;

5.2.2. Хот хоорондын зорчигч тээвэрлэлт;

5.2.3. Орон нутгийн зорчигч тээвэрлэлт;

5.2.4. Хотын доторх ба хот орчмын зорчигч тээвэр.

5.3. Зорчигч тээврийн үйлчилгээг тээвэрлэлтийн чиглэл, зорчих хөдөлгөөний дэглэмээс хамаарч дараах төрөл байна. Үүнд:

5.3.1. Ердийн;

5.3.2. Буухиа (экспресс).

6. Зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгчид нь дор дурдсан нийтлэг шаардлагыг хангасан байна. Үүнд:

6.1. Тээвэрлэгч нь нутаг дэвсгэрийнхээ эрх бүхий байгууллагад тогтоосон журмын дагуу бүртгүүлж, эрхлэх ажил, үйлчилгээний нэр, төрөл, үйл ажиллагааг тодорхой заасан улсын бүртгэлийн гэрчилгээ авсан байх.

6.2. Хуульд заасан бол холбогдох зөвшөөрлийг авсан, үйл ажиллагаа явуулах санхүүгийн чадавхтай байна.

6.3. Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн дагуу тохирлын үнэлгээ хийлгэж гэрчилгээ авсан байна.

6.4. Үйл ажиллагаандаа Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцоо. Шаардлага, хэрэглэх заавар MNS ISO 45001 стандартыг нэвтрүүлэх төлөвлөгөөтэй байна.

6.5. Ажил үйлчилгээний онцлогоос хамааран Аавтотээврийн салбарын ажил мэргэжлийн стандарт. Ерөнхий шаардлага MNS 6595 стандартад заасан мэргэжлийн хүний нөөцөөр хангагдсан байна.

6.6. Хүний нөөцийн мэдээллээ “Зам тээврийн салбарын хүний нөөцийн бүртгэл, мэдээлэл, сургалтын нэгдсэн систем”-д бүртгүүлсэн байна.

6.7. Тээвэрлэлтийн ангиллаас үл хамаарч зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэн гүйцэтгэх байгууллага нь тээвэр зохицуулагч ажиллуулна.

6.8. Зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч байгууллага нь холбогдох хууль, дүрэм, журам болон Автотээврийн хэрэгслийн ангилал. Техникийн байдалд тавих ерөнхий шаардлага MNS 4598 стандартын шаардлагад нийцсэн нийтийн тээврийн хэрэгсэл, мэргэшсэн жолооч, мэргэжлийн хүний нөөц, гарааш, засварын байр зэргээр хангагдсан байна.

7. Зорчигчийн тогтмол тээврийн үйлчилгээ эрхлэгчид тавих нэмэлт шаардлага.

7.1. Олон улс, хот хоорондын зорчигчийн тогтмол тээврийн үйлчилгээ эрхлэгчид тавих нэмэлт шаардлага.

7.1.1. “Автозогсоол. Ангилал ба ерөнхий шаардлага”. MNS 5342 стандартын шаардлага хангасан нийт тээврийн хэрэгслийн 50 хувиас доошгүйг багтаах өөрийн өмчлөлийн дулаан зогсоолтой байна.

7.1.2. “Авто үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага”. MNS 5025 стандартад нийцсэн хангасан техникийн засвар, үйлчилгээний байртай, эсхүл тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээг тухайн ангиллын тээврийн хэрэгсэлд техникийн засвар үйлчилгээ хийх тохирлын үнэлгээний гэрчилгээ авсан мэргэжлийн авто үйлчилгээний байгууллагаар гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан байна.

7.1.3. “Автомашин угаалгын үйлчилгээ. Ангилал, Ерөнхий шаардлага. MNS 5347” стандартын шаардлага хангасан автомашин угаалгын газартай гэрээ байгуулан тээврийн хэрэгслийн угаалгын үйлчилгээг хийлгэж болно.

7.1.4. Тээвэрлэлтийн явцад тээврийн хэрэгсэл эвдэрч саатсан тохиолдолд зорчигчдыг зохих газарт нь саадгүй хүргэх тээврийн хэрэгсэл, хүний нөөцтэй байна.

7.1.5. Олон улсын тээвэрлэгч нь улс хооронд тээвэрлэлт хийх зөвшөөрлийн бичиг болон бусад тээвэрлэлтийн баримт бичгийг жолоочид бүрдүүлэн өгнө.

7.1.6. Автотээврийн хэрэгсэл нь өөрийн өмчлөлийн, эсхүл эзэмшлийн байна.

7.2. Хотын доторх болон хот орчмын зорчигчийн тогтмол тээврийн үйлчилгээ эрхлэгчид тавих нэмэлт шаардлага

7.2.1. Тээвэрлэгч нь өөрийн эзэмшлийн зориулалтын дараах барилга байгууламжтай байна. Үүнд:

- 7.2.1.1.** Техникийн засвар, үйлчилгээний байр;
- 7.2.1.2.** Тээврийн хэрэгслийн угаалгын цэг;
- 7.2.1.3.** Дулаан зогсоол;
- 7.2.1.4.** Ил зогсоол;
- 7.2.1.5.** Нийтийн тээврийн үйлчилгээний диспетчерийн төв;

7.2.2. Тээврийн хэрэгслийн засвар, үйлчилгээний байр, дулаан зогсоол нь Барилгын норм ба дүрэмд заасан шаардлагуудыг хангасан, автомашины хөдөлгүүрийн ажилласан хийг зайлуулах, агааржуулах, гэрэлтүүлэх, дулаалцуулах системтэй, тэдгээр нь хэвийн ажиллагаатай байна.

7.2.3. Нийтийн тээврийн 20 автобус тутамд техникийн оношилгоо, үйлчилгээ, засварын тоноглогсон суваг эсвэл өргүүр нэг байна.

7.2.4. Нийтийн тээврийн хэрэгслийн техникийн оношилгоо, үйлчилгээ, засварын байр, дулаан гарааш, угаалгын цэг нь доорх нийтлэг шаардлагыг хангана. Үүнд:

7.2.5. Зорчигч тээврийн үйлчилгээний аж ахуйн нэгж, байгууллагууд нийтийн тээврийн хэрэгслийн гадна талыг цэвэрлэх автомат угаалгын цэгтэй байна. Уг цэг нь усыг цэвэршүүлэн дахин ашиглах нөхцөлийг хангасан байна.

7.2.6. Эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагын дагуу цэвэр, бохир усны системд холбогдсон, технологийн болон хэрэглээний халуун усаар хангагдсан, бие засах газар, ажилчдын хувцас солих болон амрах өрөөтэй байна.

7.2.6. Холбогдох шаардлагын дагуу багаж хэрэгслээр бүрэн хангагдсан галын аюулгүй байдлын цэгийг төлөвлөж байгуулсан байна.

7.2.7. Дулаан зогсоол нь нийт тээврийн хэрэгслийн 80-аас доошгүй хувийг багтаах багтаамжтай байна.

7.2.8. Ил зогсоолын зам, талбай нь хатуу хучилттай, нийт тээврийн хэрэгслийн 20-оос доошгүй хувь нь зогсох боломжтой байна.

7.2.9. Зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч нь замналын дагуух тодорхой цэгүүдэд жолооч, кондукторын түр амрах, хооллох байр, бие засах газруудыг “Авто замын дагуух үйлчилгээний цогцолбор. Ангилал, ерөнхий шаардлага” MNS 5537 стандартын дагуу зохион байгуулна.

7.2.10. Нийтийн тээврийн удирдлагын төв, цахим төлбөрийн системтэй болон харилцаа холбоо, интернэтийн сүлжээгээр шууд холбогдсон, нийтийн тээврийн үйлчилгээний ажлын цаг, ажил бэлтгэх хугацаанд тасралтгүй тээвэр зохицуулагч ажиллах боломжтой Нийтийн тээврийн үйлчилгээний диспетчерийн төвийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлд нийцүүлэн ажиллуулна.

7.2.11. Автотээврийн хэрэгсэл нь өөрийн өмчлөлийн, эсхүл эзэмшлийн байна.

7.3. Орон нутгийн болон зорчигчийн тогтмол бус тээврийн үйлчилгээ эрхлэгчид тавих нэмэлт шаардлага

7.3.1. Тээвэрлэгч нь Автозогсоол. Ангилал ба ерөнхий шаардлага. MNS 5342 стандартын хангасан нийт тээврийн хэрэгслийн 50 хувиас доошгүйг багтаах дулаан зогсоолтой байна. Дулаан зогсоол нь түрээсийн байж болно.

7.3.2. Тээвэрлэгч нь энэ стандартын 7.1.2, 7.1.3, 7.1.4-д заасан шаардлагуудыг хангасан байна.

8. Таксийн үйлчилгээ эрхлэгчид тавих шаардлага.

8.1. Таксины үйлчилгээг шуурхай зохион байгуулах, жолооч, зорчигчдын аюулгүй байдлыг хангах, хяналт тавих зорилгоор холбоо, мэдээллийн хэрэгсэл болон байрлал тогтоох, бүртгэл хяналтын төхөөрөмжтэй байна.

8.2. Тээвэрлэгч нь нийслэлд 10, орон нутагт 5-аас доошгүй такситай, үүний 60-аас доошгүй хувь нь өөрийн өмчлөлийнх, эсвэл эзэмшлийнх байна.

8.3. Тээвэрлэгч нь жолооч нарыг нэг загварын дүрэмт хувцсаар хангасан байна.

8.4. Өөрийн өмчийн, эсвэл түрээсийн үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтын барилга байгууламжтай байх бөгөөд дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

8.4.1. Техникийн засвар, үйлчилгээний зориулалтын байртай байх.

8.4.2. Дулаан гарааштай (нийт таксины 60%-аас дээш хувийг хадгалах багтаамж бүхий) байх.

8.4.3. Автомашин угаалгын байртай байх.

8.5. Тээвэрлэгч нь 10-аас 15 такси тутамд засвар үйлчилгээний 1-ээс доошгүй суваг болон өргүүртэй байх.

8.6. Техникийн оношилгоо, үйлчилгээ, засварын байр, дулаан гараашийн барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмж нь БНБД 31-03-03 барилгын норм дүрэмд заасан шаардлагыг хангасан байна.

8.7. Тээвэрлэгч нь такси үйлчилгээнд ажиллаж буй жолоочийг тогтсон тарифын дагуу үйлчилж байгаа эсэхийг шалгах, хөдөлгөөнт төхөөрөмжид зориулсан такси үйлчилгээний программ хангамж ашигладаг бол тухайн программ хангамжид үйлчилгээний тарифыг жолооч өөрчлөх боломжгүй байна.

9. Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээнд ажиллах тээврийн хэрэгсэлд тавих нийтлэг шаардлага

9.1. Нийтийн тээврийн хэрэгсэл нь техникийн хувьд бүрэн бүтэн, зорчигчийг баруун гар тал руугаа буулгаж, суулгах нөхцөлийг хангасан, "Автотээврийн хэрэгслийн ангилал. Техникийн байдалд тавих ерөнхий шаардлага. MNS 4598" болон "Автотээврийн хөдлөх бүрэлдэхүүний эргономикийн үзүүлэлтүүд. MNS 4599" стандартуудын шаардлагыг бүрэн хангасан техникийн хяналтын үзлэгт хамрагдаж тэнцсэн байна.

9.2. Нийтийн тээврийн үйлчилгээнд ажиллах тээврийн хэрэгслийн ашиглалтын хугацаа хүснэгт 1-т зааснаас хэтрэхгүй байна.

Хүснэгт 1

№	Үйлчилгээний ангилал, төрөл	Ашиглалтын хамгийн их хугацаа
1	Хотын доторх болон хот орчмын тогтмол тээврийн үйлчилгээ	10 жил

2	Олон улс, хот хооронд, орон нутгийн зорчигчийн тогтмол тээврийн үйлчилгээ	12 жил
3	Хүүхэд тээвэрлэх үйлчилгээ	12 жил
4	Жуулчин тээвэр, ажилчид тээвэрлэх болон бусад захиалгат зорчигчийн тогтмол бус тээврийн үйлчилгээ	12 жил
5	Таксийн үйлчилгээ	10 жил

9.3. Бага багтаамжийн автобусанд анхны тусламжийн зориулалтын иж бүрдэл 1, их, дунд багтаамжийн болон хүүхдийн автобусанд 3-аас цөөнгүй байх бөгөөд анхны тусламжийн иж бүрдэл дэх эм, хэрэгсэл, нь ашиглалтын шаардлага хангасан, хугацаа дуусаагүй, нэр шошго нь арилаагүй байна.

9.4. Их, дунд багтаамжийн автобусанд тухайн тээврийн хэрэгслийн дугуйны хэмжээнд тохирсон өнхрөлтийн эсрэг зориулалтын 2-оос цөөнгүй ивүүр, бусад дугуйн хэмжээтэй тохирох нөөц дугуй болон өргүүр, ослын тэмдэг, гал унтраагуур гэх мэт шаардлагатай багаж хэрэгсэлтэй байна.

9.5. Нийтийн тээврийн хэрэгслийн үйлдвэрлэгчийн таних тэмдэг VIN дугаар нь засваргүй, “Автотээврийн хэрэгслийн дэлхийн үйлдвэрлэгчийг таних тэмдэг(WMI)-ийн код” MNS ISO 3780, “Автотээврийн хэрэгслийн таних тэмдгийн дугаар (VIN) - Агуулга ба бүтэц” MNS ISO 3779 стандартуудын шаардлага хангасан байна.

9.6. Зорчигч тээврийн хэрэгсэл нь жилд 2 удаа техникийн хяналтын үзлэгт хамрагдсан байна.

9.7. Зорчигч тээвэрлэх автобус, такси нь стандартын шаардлага хангасан, зүүн гар талдаа жолооны хүрдтэй, зорчигчийг баруун гар тал руугаа буулгаж, суулгах нөхцлийг хангасан байна.

9.8. Зорчигч тээврийн үйлчилгээний автобус нь 1-2 хаалгатай байна.

9.9. Хотын доторх болон хот орчмын үйлчилгээнд ашиглахаас бусад нийтийн тээврийн хэрэгслийн суудал бүр нь хамгаалах бүсээр тоноглогдсон, тэдгээр нь бүрэн ажиллагаатай байна.

9.10. Нийтийн тээврийн хэрэгсэл дээрх бичээс нь “Монгол хэлний компьютерын орчны тогтолцоо. Кирилл ба монгол үсгийн нэгдсэн код MNS 5552:2005 стандартын /Arial font/ шаардлага хангасан байна.

9.11. Зорчигчдын танхим нь эрүүл ахуй, ариун цэвэр, галын болон хөдөлгөөний аюулгүйн шаардлагыг бүрэн хангасан, ослын нэмэгдэл цонх, нээлхийтэй байна.

9.12. Нийтийн тээврийн хэрэгсэл нь дулаацуулгын систем, сэрүүцүүлэх систем (air conditioner)-аар бүрэн тоноглогдсон байх бөгөөд хэвийн ажиллагаатай байна.

10. Зорчигч тээврийн үйлчилгээний тээврийн хэрэгсэлд тавих нэмэлт шаардлага

10.1. Олон улс, хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээнд ажиллах тээврийн хэрэгсэлд тавих нэмэлт шаардлага

10.1.1 тээвэрлэлт гүйцэтгэх тээврийн хэрэгсэл нь тээврийн хэрэгслийн хөдөлгөөн болон жолоочийн ажлын тодорхой хугацааны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг автоматаар, эсхүл хагас автоматаар бүртгэж, харуулах зориулалттай хяналтын төхөөрөмжөөр тоноглогдсон байна. (Энэ заалтыг 2027 оны 01 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдөнө)

10.1.2. Тээврийн хэрэгслүүд өөр хоорондоо болон тээвэрлэлтийн үйл ажиллагааг зохицуулах, зохион байгуулах үүрэг бүхий байгууллагын удирдлага, хяналтын төвтэй холбогдох мэдээлэл холбооны хэрэгслээр хангагдсан байна.

10.1.3. Тээврийн хэрэгслүүд нь үйлчилгээний аюулгүй байдал, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор гадна болон дотор талд хяналтын камераар тоноглогдсон байна.

10.1.4. Олон улсын тээвэрлэлтэд ажиллах тээврийн хэрэгсэл нь “MGL” ялгах тэмдэг болон олон улсад танигдах үсэг, тоо бүхий улсын бүртгэлийн дугаарын тэмдэгтэй байна.

10.1.5. Олон улсын зорчигчийн тогтмол тээврийн үйлчилгээнд 24 болон түүнээс дээш хүний суудалтай, зорчигчийн гар тээшний тавиур, ачаа тээшний зориулалтын хонгилтой их

багтаамжийн автобусыг ашиглах бөгөөд автобусны хажуу талд Монгол Улсын соёмбо бүхий таних тэмдэгтэй, **“Улс хоорондын зорчигч тээвэр”** гэсэн бичвэр бүхий туузыг нийтэд харагдахаар байрлуулсан байна.

10.2. Хотын доторх болон хот орчмын нийтийн тээврийн үйлчилгээнд ажиллах тээврийн хэрэгсэлд тавих нэмэлт шаардлага

10.2.1. Нийтийн тээврийн хэрэгслийн чиглэлийн хаяг нь цахим дэлгэц бүхий замналын нэр, дугаар, эцсийн ба дундын зогсоолуудын нэрийг нийтэд харагдахаар байрлуулсан байна.

10.2.2. Нийтийн тээврийн хэрэгсэл нь 2 хаалгатай бол зорчигч суух болон буух тэмдгээр ялгасан байна.

10.2.3. Нийтийн тээврийн хэрэгсэл нь зориулалтын бүрэн бүтэн суудал, бариул, зорчигчдын заал нь бүрэн ажиллагаа бүхий гэрэлтүүлэх ба дулаацуулах систем, зарлан мэдээллийн хэрэгсэл болон хяналтын камертай байна.

10.2.4. Нийтийн тээврийн хэрэгсэл нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэн доорх тусгай тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байна. Үүнд:

10.2.4.1. Хөгжлийн бэрхшээлтэй тэргэнцэртэй зорчигч суух, буух боломжтой тавцан, нэмэлт төхөөрөмж, зорчих зориулалтын бэхэлгээ бүхий талбайтай байх;

10.2.4.2. Сонсголын бэрхшээлтэй иргэнд зориулан чиглэлийн болон зогсоолуудын нэр бүхий цахим самбар, дэлгэцтэй байх;

10.2.4.3. Харааны бэрхшээлтэй иргэнд зориулан автомат зогсоол зарлагч болон чанга яригчтай байх.

10.2.5. Угсраа болон давхар автобусыг зөвхөн хотын доторх болон хот орчмын зорчигч тээвэрлэлтийн үйлчилгээнд ашиглана. Угсраа болон давхар автобусны хойд талд тээврийн хэрэгслийн оврын хэмжээгээр бусад хөдөлгөөнд оролцогч нарт харагдахаар цацруулагч наалт наасан байна.

10.2.6. Нийтийн тээврийн бага багтаамжийн автобусанд доор дурдсан нэмэгдэл шаардлагыг тавина. Үүнд:

- Харьяалах аж ахуйн нэгж, байгууллагын эмблем (лого), гараашийн дугаар, чиглэлийн нэр, дугаарыг баталсан загварын дагуу зорчигчдод ил тод харагдах газар бичиж байрлуулна.
- Бага багтаамжийн автобусны хоёр хажуу талд "Нийтийн тээвэр" гэсэн бичээс бүхий туузыг нийтэд тод харагдахаар бичиж байрлуулна. Хэмжээ загварыг тээврийн хэрэгслийн овроос хамааруулан Нийтийн тээврийн үйлчилгээнд эрх олгож буй байгууллага нэгдсэн ижил загвараар баталгаажуулна.

10.2.7. Нийтийн тээврийн автобус, троллейбусанд харьяалах аж ахуйн нэгж, байгууллагын эмблем (лого), паркийн дугаар, чиглэлийн нэр, дугаарыг баталсан загварын дагуу зорчигчдод ил тод харагдах газар байрлуулна. Үүнд:

- Паркийн дугаарыг автобусны хоёр хажуу, ар талд болон дээвэр дээр, чиглэлийн хаягийг урд, хоёр хажуу, ар талд цахим болон бусад хэлбэрээр байрлуулна.
- Нийтийн тээврийн хэрэгслийн паркийн дугаар, чиглэлийн хаяг, иргэдээс санал, гомдол, мэдээлэл авах зурагт хуудасны загварыг Нийтийн тээврийн үйлчилгээнд эрх олгож буй байгууллага нэгдсэн ижил загвараар баталгаажуулна.
- Зохицуулалтаар болон нэмэлтээр бусад чиглэлд ажиллах нөхцөлд чиглэлийн түр хаягийг батлагдсан загварын дагуу ашиглана.

10.2.8. Байгалийн хий (CNG, LNG)-н болон цахилгаан хөдөлгүүртэй нийтийн тээврийн хэрэгсэлд галын аюулаас урьдчилан сэргийлэх зориулалтын тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг байрлуулсан байна.

10.2.9. Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээнд хотын дотор ажиллах тээврийн хэрэгсэл нь удирдлага мэдээлэл болон цахим төлбөрийн системийн тоног төхөөрөмжөөр бүрэн

тоноглогдсон байна.

10.2.10. Нийтийн тээврийн хэрэгслийн чиглэлийн хаяг нь эрх олгож буй байгууллагаас баталгаажуулсан загварын дагуу цахим дэлгэц бүхий удирдлага мэдээлэл болон цахим төлбөрийн системтэй уялдсан байна.

10.2.11. Нийтийн тээврийн үйлчилгээнд ажиллах тээврийн хэрэгсэл нь (үйлдвэрлэгчээс зориулалтын дагуу ирснээс бусад) үзэгдэх орчин хязгаарласан нэмэлт хуулга, өнгөт хальс зэрэг наалтгүй байна.

10.3. Таксийн үйлчилгээнд ажиллах тээврийн хэрэгсэлд тавих нэмэлт шаардлага

10.3.1. Зорчигчийн суудал бүр хамгаалах бүсээр тоноглогдсон, тэдгээр нь бүрэн ажиллагаатай байна.

10.3.2. Таксийн таних тэмдэг нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Таних тэмдгийн хэмжээ нь уртын дагуу 600 мм х 60 мм-ээс, доторх шоонууд нь 30 мм х 30 мм-ээс багагүй хэмжээтэй хар, цагаан эсвэл ногоон өнгө алгасан хосолсон байна.
- Тээвэрлэгчийн лого нь таксины урд талын 2 хаалган дээр 350 мм х 200 мм- ийн хэмжээс бүхий хүрээнд багтсан байна.
- Таксины гараашны дугаар нь арын салхины шилний 2 талын баганад 140 мм х 80 мм хэмжээтэй байна.
- Паркийн болон харилцах утасны дугаарын нэг тооны хэмжээ нь 45 мм х 30 мм байна.
- Таксины бүхээгт байгууллагын нэр, жолоочийн өнгөт зураг, овог нэр, автомашины улсын ба паркийн дугаарыг А5 хэмжээнээс багагүй хүрээнд бичиж зорчигчдод харагдах газар хөдөлгөөнгүйгээр байрлуулна.

10.3.3. Спидометргүй, таксометргүй болон тэдгээр нь лац ломбогүй, баталгаажаагүй, эвдэрч гэмтсэн бол үйлчилгээнд гаргахыг хориглоно. Хөдөлгөөнт төхөөрөмжид зориулсан такси үйлчилгээний программ хангамжийн суурилах төхөөрөмж нь ажиллагааны бүрэн бүтэн байдлыг хангаагүй бол үйлчилгээнд гаргахыг мөн хориглоно.

10.4. Хүүхэд тээвэрлэх автобусанд тавих нэмэлт шаардлага

10.4.1. Автобус нь шар өнгөтэй байна.(А хавсралт)

10.4.2. Автобус нь хөдөлгөөний хяналтын төхөөрөмж, чанга яригч, зогсоол зарлах төхөөрөмжөөр тоноглогдсон байна. Хүүхэд тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хангах зорилгоор автобус нь 3-аас доошгүй онлайн горимд ажиллах камераар тоноглогдсон байна. Үүнд:

- Тээврийн хэрэгслийн урд салхины шилэнд ойрхон байрлах гадна хөдөлгөөнийг хянах камер,
- Зорчигчийн танхимын хойд хэсэгт урагш харан байрлах доторх хөдөлгөөнийг хянах камер,
- Зорчигчийн танхимын баруун урд хэсэгт хойш харан байрлах доторх хөдөлгөөнийг хянах камер.

10.4.3. Хөгжлийн бэрхшээлтэй зорчигчийн буух, суух нөхцөлийг хангасан тавцантай байна.

10.4.4. Хүүхдийг харгалзан явах 1-ээс доошгүй насанд хүрсэн хүнд зориулсан хүүхдүүдэд хяналт тавьж болохуйц байршлын суудалтай байна.

10.4.5. Хаалганы бариул нь хүүхэд хаалганы дэргэд эсвэл аль нэг гишгүүр дээр зогсоод түүнээс барих боломжтой байхаар байрласан байна.

10.4.6. Хүүхэд тээвэрлэх автобусны хоёр хажуу талд дармал том үсгээр **“ХҮҮХДИЙН АВТОБУС”** гэсэн бичээс бүхий туузыг нийтэд тод харагдахаар байрлуулна.(С хавсралт)

10.4.7. Замын хөдөлгөөний дүрэмд заасны дагуу улаан хүрээтэй, шар өнгийн дэвсгэр бүхий дөрвөлжин (нэг талын урт нь 250 мм-ээс багагүй, хүрээний өргөн нь нэг талын хэмжээний 1/10-тэй тэнцүү) дотор хар өнгөөр 1.18 тэмдгийн доторх дүрсийг зурсан **“Хүүхэд тээвэрлэж яваа тээврийн хэрэгсэл”** гэсэн таних тэмдгийг автобусны урд болон хойд талд байрлуулна.

10.4.8. Хүүхэд буулгаж, суулгах үеийн аюулгүй байдлыг хангах, замын хөдөлгөөнд оролцогчдод анхааруулах үүднээс шар өнгийн өнгийн анивчсан тусгай гэрэл дохиогоор бусдад харагдахуйц байрлалд тоноглогдсон байна.

10.4.9. Автобусны зүүн гар талд, урд хэсгээс 1800 мм-ээс 2000 мм зайд Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн 1 дүгээр хавсралтын 3.5-д заасан “ЗОГСОХГҮЙ ЯВАХ ХОРИОТОЙ” тэмдгийг эвхэгддэг байдлаар байрлуулсан байна (В хавсралт). Зорчигч бууж, суух үед жолооч тухайн тэмдгийг зорчих хэсэг рүү харуулан дэлгэх ба хөдөлгөөнд оролцох үедээ хураасан байдалд байрлуулна. Тэмдэг нь хөдөлгөөний үед савахгүй, дэлгэхэд хүндрэлгүй, түгжигддэг байна. Тэмдэг нь автомат ажиллагаатай байж болох ба техникийн гэмтлээс шалтгаалахгүй гараар нээгдэж хаагддаг, түгжигддэг байж болно.

10.5. Жуулчин тээврийн үйлчилгээнд ажиллах тээврийн хэрэгсэлд тавих нэмэлт шаардлага

10.5.1. Тээврийн хэрэгсэл нь урд болон ар талдаа англи, монгол хэл дээр “**Tourist (Жуулчин)**” гэсэн бичээс бүхий таних тэмдэгтэй байна. Уг таних тэмдэг нь дөрвөлжин хэлбэртэй, 250мм х 300мм хэмжээтэй, улаан хүрээтэй, хүрээний өргөн нь талын хэмжээний 1/10-тэй тэнцүү, бичээс нь цэнхэр өнгөтэй байна.

10.5.2. Жуулчин тээврийн үйлчилгээнд ажиллах тээврийн хэрэгслийн урд талд гадна талыг хянах, бичлэг хийх видео камертай байх бөгөөд 48 цагаас багагүй хугацааны бичлэг хадгалах багтаамжтай байна.

11. Зорчигч тээврийн үйлчилгээнд ажиллах хүний нөөцөд тавих шаардлага

11.1. Зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж, байгууллага нь автотээврийн салбарын мэргэжилтэй хүний нөөцөөр хангагдсан, тэдгээр нь ажил үүрэг, мэргэжлийнхээ чиглэлээр холбогдох мэргэшүүлэх сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байна.

11.2. Жолооч нь тухайн ангиллын тээврийн хэрэгслийг жолоодох эрхийн үнэмлэхтэй, эрүүл мэндийн үзлэгт орж тэнцсэн, тухайн тээврийн үйлчилгээний чиглэлээр мэргэшүүлэх сургалтад хамрагдаж, үнэмлэх авсан, 21-ээс дээш насны хүн байна. Угсраа болон давхар автобусны жолооч нь дээрх шаардлагыг хангасан жолоочийн мэргэжлийн "Д" ангиллын тээврийн хэрэгслийг 3-аас дээш жил жолоодож дадлагажсан байна.

11.3. Олон улсын тээвэрлэлт гүйцэтгэх жолооч нь 5-аас доошгүй жил тээврийн хэрэгсэл жолоодсон, үүний дотор дотоодын зорчигч тээврийн үйлчилгээний жолоочоор 2-оос доошгүй жил ажилласан байна.

11.4. Жолооч нь тээврийн хэрэгсэлд тохиолдсон эвдрэл гэмтлийг оношлох, хөнгөн гэмтлийг засварлах чадвартай, эмнэлгийн анхны тусламж үзүүлэх чиглэлээр сургалтад хамрагдсан байна.

11.5. Кондуктор, шалгагч нь ерөнхий боловсролын суурь болон бүрэн дунд боловсролтой, 18-аас дээш настай, эрүүл мэндийн шаардлага хангасан, мэргэжлийн сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байна.

11.6. Хүүхдийн автобусны жолооч нь гэмт хэрэгт холбогдож байгаагүй байх.

12. Зорчигч тээврийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага

12.1. Тээвэрлэлт эхлэхийн өмнө жолоочийг эрүүл мэндийн анхан шатны үзлэгт хамруулан, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгаа өгч, мөн тээврийн хэрэгслийн техникийн бүрэн байдлыг шалгаж, баталгаажуулна.

12.2. Гар тээш нь олон улсын зорчигч тээвэрлэлтэд 60х40х20 см-ээс илүүгүй овор хэмжээтэй, 30 кг-аас хэтрэхгүй, хот хооронд, орон нутгийн зорчигч тээвэрлэлтэд 60х40х20 см-ээс илүүгүй овор хэмжээтэй, 20 кг-аас хэтрэхгүй жинтэй, хотын доторх болон хот орчмын зорчигч тээвэрлэлтэд 60х30х20 см-ээс илүүгүй овор хэмжээтэй, 15 кг-аас хэтрэхгүй жинтэй байна.

12.3. Тээвэрлэгч нь хэмжээ, шинж чанараараа бусад тээшинд нөлөөлөхгүй, тээшний хонгилд ачиж байрлуулах боломжтой бүрэн бүтэн сав, баглаа, боодолтой тээшийг зорчигчоос хүлээн авч тээвэрлэнэ.

12.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, жирэмсэн, нялх хүүхэдтэй эхчүүд, бага насны хүүхэд,

өндөр настан зэрэг хүмүүсийг нийтийн тээврийн хэрэгсэлд суух ба буух, зорчих үед нь жолооч, кондуктор, шалгагч бусад зорчин явагчид анхаарал хандуулж, тусалцаа үзүүлнэ.

12.5. Нийтийн тээврийн хэрэгсэл дотор чиглэл, замналын зураглал, үйлчилгээтэй холбоотой санал гомдол, мэдээлэл өгөх утасны дугаар, цахим хаяг, үйлчилгээ, үйл ажиллагаатай холбоотой санамжууд, тамхи татах, ил гал гаргахыг хориглосон тэмдэг, заалт, бусад санамжийг зохих стандартын дагуу байрлуулсан байна.

12.6. Тээвэрлэлтийн үед жолооч нь тээврийн хэрэгсэлд учирсан техникийн эвдрэл, гэмтлийн талаар холбогдох албан тушаалтанд мэдэгдэж, саатлыг арилгах, техникийн түргэн тусламж авах, эвдрэлийг арилгуулах, зорчигчийг шилжүүлэн суулгах яаралтай арга хэмжээ авна.

12.7. Осол, аюулын үед ажиллах аюулгүй ажиллагааны зааварчилгаа, холбогдох байгууллага, албан тушаалтанд яаралтай мэдэгдэх, эрсдэлд өртөгсдөд анхны тусламж үзүүлэх, аврах, шаардлагатай арга хэмжээ авах шуурхай арга хэмжээний бүдүүвчтэй байна.

12.8. Өвлийн улиралд дулаацуулгын систем, зуны улирал сэрүүцүүлэх систем (air conditioner)-ийг бүрэн ажиллуулж, зорчигчдын тав тухтай байдлыг хангана.

12.9. Тээврийн хэрэгсэл бүрийг угаах, цэвэрлэх, арчих хэрэгсэл, ариутгаж, халдваргүйжүүлэх материалаар хангасан байна.

12.10. Зорчигч тээврийн үйлчилгээнд ажиллагсдыг ажлын хувцас, зураг, нэр бүхий нэрийн хуудастай ажиллуулна.

12.11. Үйлчилгээнд гарахын өмнө тээврийн хэрэгслийн дотор, гадна талыг бүрэн цэвэрлэсэн байна.

12.12. Зорчигч тээврийн үйлчилгээний жолооч нь дараах нийтлэг үүргийг хүлээнэ. Үүнд:

- хөдөлгөөний үед жолоочийн бүхээгт хүн суулгах, тамхи татах, гар утсаар хэт удаан ярих, зорчигчдын танхимд дуу хөгжим чанга тавих, зөвшөөрсөн хурдыг хэтрүүлэх, хэт удаан явах, зогсоолын бус газарт хүн буулгах ба суулгах, батлагдсан замналаас хазайж өөр зам, замнал сонгох, хөдөлгөөний цагийн хуваарь зөрчихгүй байх;
- Үйлчилгээний явцад тээврийн хэрэгслийн тоног төхөөрөмж, эд хогшлыг гэмтээсэн, зорчигчдыг тав тухтай зорчиход саад учруулсан, бусдын эрх чөлөөнд халдаж, танхайрсан, хулгайн хэрэг гарсан зэрэг зөрчлийн үед хөдөлгөөнийг зогсоож, шаардлагатай арга хэмжээ авах;
- Зам, тээврийн ослоос урьдчилан сэргийлэхээс бусад тохиолдолд шалтгаангүйгээр нийтийн тээврийн хэрэгслийг огцом тоормосолж гэнэт зогсоох, хөдлөх зэргээр зорчигчдын тав тухыг алдагдуулахгүй байх;
- Техникийн шаардлага хангаагүй тээврийн хэрэгслээр тээвэрлэлтийн үйлчилгээ үзүүлэхээс татгалзах.

12.13. Зорчигчдын амь нас, эрүүл мэнд, эд зүйл болон тээврийн хэрэгсэлд аюул хохирол учруулж болзошгүй химийн болон аюултай бодис, мал, хамгаалалтгүй тэжээвэр амьтан, шувуу, амьтны гаралтай түүхий эд тээвэрлэхгүй.

13. Зорчигчийн тогтмол тээврийн үйлчилгээнд тавих нэмэлт шаардлага

13.1. Олон улс, хот хоорондын зорчигчийн тогтмол тээврийн үйлчилгээнд тавих шаардлага

13.1.1. Тээвэрлэгч нь тээвэрлэлтийн явцад зам, тээврийн осол, байгалийн давагдашгүй хүчин зүйл, гэнэтийн ослын үед зорчигчийн амь нас, эрүүл мэнд, ачаа тээшинд учирсан хохирлыг барагдуулах даатгалд хамрагдсан байна.

13.1.2. Тээвэрлэлтийн явцад хөгжим хэт чанга тавьж, зорчигчдын тав тухыг алдагдуулах, стандартын шаардлага хангахгүй зам дагуух үйлчилгээний төв, түр амрах цэгт зогсохгүй.

13.1.4. Жолооч нь үүсэж болзошгүй аливаа эрсдэлээс өөрийгөө болон асран хамгаалж яваа бага насны хүүхдийн аюулгүй байдлыг хангах талаар зорчигчдод мэдээлэл, зөвлөмж өгнө.

13.1.5. 500 км-ээс хол зайд тээвэрлэлт гүйцэтгэхдээ жолоочийн хөдөлмөр, амралтын горимыг

мөрдөж, шаардлагатай тохиолдолд ээлжийн жолоочтой байна.

13.1.6. Жолоочийн хөдөлмөр, амралтын горимын талаарх мэдээллийг бүртгэх хуудсанд хөтлөх, эсвэл хяналтын төхөөрөмжид хадгална.

13.1.7. Олон улсын зорчигчийн тогтмол бус тээвэрлэлтэд зорчигчийн нэрсийн жагсаалтыг агуулсан дагалдах хуудсыг олгох бөгөөд тэдгээр нь монгол болон тухайн харилцагч улсын хэл дээр хэвлэгдсэн байна.

13.2. Хотын дотор болон хот орчмын зорчигчийн тогтмол тээврийн үйлчилгээнд тавих нэмэлт шаардлага

13.2.1. Зорчигч тээврийн үйлчилгээнд хурд хэтрүүлэх, хэт удаан явах, тээврийн хэрэгслийн багтаамжаас илүү зорчигч тээвэрлэх, зорчигчийн зааланд гар тээшнээс бусад ачаа тээш тээвэрлэхийг хориглоно.

13.2.2. Тээвэрлэгч нь үйлчлэх чиглэлийн эцсийн болон дундын зогсоолд, хөдөлгөөний цагийн хуваарь, тээвэрлэлтийн зай, хоногт гүйцэтгэх рейсийн тоо зэрэг замналын үзүүлэлтүүдийг төлөвлөж баталгаажуулсан байна.

13.2.3. Тээвэрлэгч нь үйлчилгээнд ажиллах тээврийн хэрэгслийг үйлчилгээнд гарахын өмнө дотор, гадна талыг угаалгаж, зорчигчдын суудал, түшлэг, бариул зэргийг арчиж, бүрэн цэвэрлэгээ хийж, шаардлагатай тохиолдолд ариутгал, халдваргүйжүүлэлтийг зохих зааврын дагуу хийнэ. Мөн үйлчилгээний явцад тогтоосон хуваарийн дагуу цэвэрлэгээ үйлчилгээ, ариутгал, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийнэ.

13.2.4. Тээвэрлэлтийн явцад зорчигчдыг аюул осолгүй, тав тухтай зорчих нөхцөлийг бүрэн хангаж тээвэрлэлтийн замнал, хөдөлгөөний цагийн хуваарийг чанд баримтлан ажиллана.

13.2.5. Үйлчилгээний явцад замд эвдэрсэн тээврийн хэрэгсэлд техникийн түргэн тусламж үзүүлэх, үйлчилгээний хяналт зохицуулалт хийх, тээвэрлэлтийн мэдээ, мэдээлэл өгөх, авах зориулалтын холбоо, мэдээллийн хэрэгслээр хангасан байна.

13.2.6. Тээвэрлэгч аж ахуйн нэгж байгууллагууд шаардлагатай үед яаралтай техникийн түргэн тусламж үзүүлэх нөхцөлийг хангасан байна.

13.2.7. Тээвэрлэгч нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг аюулгүй, чөлөөтэй зорчих нөхцөлийг бүрдүүлэн тусгайлсан тэмдэглэгээ бүхий суудал, орон зайг гаргаж үйлчилнэ.

13.2.8. Зорчигч тээврийн үйлчилгээний хэвийн тасралтгүй, шуурхай байдлыг Нийтийн тээврийн удирдлагын төвөөр хангаж, мэргэжлийн тээвэр зохицуулагч ажиллуулна. Тээвэрлэгч байгууллагууд өөрийн тээвэр зохицуулагчаараа дамжуулан Нийтийн тээврийн удирдлагын төвийн шууд удирдлагад ажиллана.

13.2.9. Хотын доторх ба хот орчмын зорчигч тээврийн үйлчилгээнд Удирдлага мэдээлэл болон цахим төлбөрийн системийг ашиглаж үйлчилгээнд ажиллаж байгаа бүх нийтийн тээврийн хэрэгслийг холбосон байна.

13.2.10. Тээврийн үйлчилгээний аюулгүй, тав тухтай, хурдан шуурхай байдлыг хангах зорилгоор зорчигч тээвэрлэлтийн төлөвлөлт, хөдөлгөөний цагийн хуваарийг нийтийн тээврийн мэдээллийн санд цугларсан зорчигч урсгал болон бусад шаардлагатай судалгаанд үндэслэн нийтийн тээврийн үйлчилгээнд эрх олгож буй байгууллага боловсруулна.

13.2.11. Хөдөлгөөний үед жолоочийн бүхээгт хүн суулгах, тамхи татах, гар утсаар хэт удаан ярих, зорчигчдын танхимд дуу хөгжим чанга тавих, зөвшөөрсөн хурдыг хэтрүүлэх, хэт удаан явах, зогсоолын бус газарт хүн буулгах ба суулгах, батлагдсан замналаас хазайж өөр зам, замнал сонгох, хөдөлгөөний цагийн хуваарь зөрчихийг хориглоно.

13.2.12. кондуктор, шалгагч нь соёлч боловсон харьцаатай, зарчимч шаардлагатай, хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй харьцах зохих мэдлэгтэй, үнэнч шударга ажиллаж, зорчигчдод хөнгөн шуурхай, үйлчилнэ.

13.2.13. Кондуктор, шалгагч нь цэвэр үзэмжтэй хувцаслаж, байгууллагын таних тэмдэг бүхий ажлын хувцас /халат/-тай, өөрийн зураг, нэр бүхий энгэрийн хуудас зүүсэн байна.

13.2.14. Кондуктор, шалгагч нь зорчигчдоос тогтоосон тарифын дагуу зорчих хөлсийг хурааж

MNS 5012

авах ба түүнд тохирсон үнэ бүхий тасалбарыг зорчигчийн өмнө урж хүчингүй болгож өгнө.

13.2.15. Шалгагч нь зорчигч тээврийн үйлчилгээтэй холбоотой болон тээврийн хэрэгсэл, жолоочтой холбоотой зөрчил дутагдал, мэдээллийг яаралтай эрх бүхий төрийн байгууллагад мэдэгдэж, арга хэмжээ авна.

13.2.16. Шалгагч нь зөрчилтэй зорчигчийг зорчуулахгүй байх арга хэмжээ авна.

13.3. Зорчигчийн тогтмол бус тээврийн үйлчилгээнд тавих нэмэлт шаардлага

13.3.1. Зорчигчийн тогтмол бус тээврийн үйлчилгээг зохион байгуулахдаа энэ стандартаар тогтоосон үйлчилгээний нийтлэг шаардлагыг хангана.

13.3.2. Тусгай сонирхлын аялал жуулчлалын тээврийн үйлчилгээг зөвхөн аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага, тур оператор өөрийн өмчлөлийн, эзэмшлийн тээврийн хэрэгслээр батлагдсан аяллын хөтөлбөрийн дагуу гүй

цэтгэнэ.

13.3.3. Тусгай сонирхлын аялал жуулчлалын тээвэрлэлтийн аюулгүй байдлыг тухайн аяллыг зохион байгуулж буй аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага, тур оператор хариуцна.

А хавсралт
(норматив)

Хүүхдийн автобусны ерөнхий байдал



В хавсралт
(норматив)

Эвхэгддэг “ЗОГСОХГҮЙ ЯВАХ ХОРИОТой” тэмдгийг харагдах байдал



В. 1 -р зураг -Дэлгэсэн байдал



В.2-р зураг - Эвхсэн байдал

С хавсралт
(норматив)

“ХҮҮХДИЙН АВТОБУС” БИЧЭЭСИЙН ХЭМЖЭЭ



С.1-р зураг - “ХҮҮХДИЙН АВТОБУС”-ны бичээсийг хийх загвар

НОМ ЗҮЙ

Олон улсын автотээврийн харилцааны тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр;